

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Санхүүгийн аудитын баг

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

### ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ХӨА-2021/01/СТА-ТЭЗ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Мөрөн 2021 он

---

Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор О.Ганболд  
Утас: 99382500 Цахим хаяг: [Ganboldo@audit.gov.mn](mailto:Ganboldo@audit.gov.mn)  
Аудитын менежер Э.Бат-эрдэнэ  
Утас: 99382811 Цахим хаяг: [Bat-erdenee@audit.gov.mn](mailto:Bat-erdenee@audit.gov.mn)  
Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [Tegshdelgerb@audit.gov.mn](mailto:Tegshdelgerb@audit.gov.mn)  
Аудитор Б.Давааням  
Утас: 99629233 Цахим хаяг: [Davaanyamb@audit.gov.mn](mailto:Davaanyamb@audit.gov.mn)  
Аудитор С.Гансүх  
Утас: 95908400 Цахим хаяг: [Gansukhs@audit.gov.mn](mailto:Gansukhs@audit.gov.mn)  
Аудитор Л.Мандахнаран  
Утас: 88111896 Цахим хаяг: [MandakhnaranL@audit.gov.mn](mailto:MandakhnaranL@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

---

## Агуулга

1. Аудитын тайлан баталгаажуулах тушаал, гэрчилгээ .....	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан .....	6
2.1. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	6
2.2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	6
2.3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4. Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	10
2. Нийгмийн даатгал, Татварын цахим системтэй холбогдоогүй байна. ....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт .....	10
3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	11
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	12
3.5.3 Авлага .....	12
3.5.4 Урьдчилгаа .....	13
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	13
3.5.6 Бараа материал .....	14
3.5.7 Үндсэн хөрөнгө .....	15
3.5.8 Өр төлбөр .....	16
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо .....	18
3.5.10 Орлогын данс .....	18
3.5.11 Зардлын данс .....	19
3.6 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	20
3.7 Шилэн дансны мэдээлэл .....	21
3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	21
3.10 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	22
4. Менежментийн захидал .....	23
4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал .....	23
4.2 үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал .....	23
4.3 сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал .....	23
4.4 өр төлбөрийн данстай холбоотой асуудал .....	24
4.4 харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд гарсан алдаа, зөрчилтэй холбоотой асуудал .....	24
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	25

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1. Аудитын тайлан баталгаажуулах тушаал, гэрчилгээ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/03

Мөрөн сум

#### Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/64 дугаар тушаал, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаал, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газар, Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид тус тус хүргүүлсүгэй.
4. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Ш.Идэрбаясгалан)-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор (Б.Тэгшдэлгэр)-т үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Э.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

О. Жаоиммагийн ГАНБОЛД



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67123. Хөвсгөл аймаг. Мөрөн сум, Урандөш баг  
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93  
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn  
Вэбсайт: www.audit.mn

2021.04.20 № 01/432  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ  
Ш.ИДЭРБАЯСГАЛАН ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв, санхүүгийн хувьд төсвийг төлөвлөх, төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх, үүрэг хэрэгжүүлэхээс гадна Монгол улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргатай 2020 онд хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан ба гэрээний биелэлт 98.6 хувьтай байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

2

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style.

О.ГАНБОЛД

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		31,770,749.9	40,601,024.7
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	8,657,636.4	11,773,924.4
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	6,471,563.7	7,171,189.7
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	8,233.4	104,733.4
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	14,667,703.5	19,131,641.9
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	166,476.4	236,111.6
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	10	1,799,136.5	2,183,423.7
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		228,614,615.0	268,677,386.6
37	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	11а, 11б	1,351,728.2	2,066,920.2
37200	Үнэт цаас		0.0	0.0
37300	Урт хугацаат зээл		1,351,728.2	2,066,920.2
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	227,262,886.8	266,610,466.4
39200	Биет хөрөнгө		207,305,712.4	246,569,782.9
39300	Биет бус хөрөнгө	13	19,957,174.4	20,040,683.6
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		260,385,364.9	309,278,411.3
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		9,956,120.3	20,218,866.6
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	6,074,408.1	8,994,167.3
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	56,100.0	336,257.2
41300	Өглөг	17а, 17б	6,003,393.8	8,503,209.7
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	14,914.2	154,700.4
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		3,881,712.2	11,224,699.3
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	3,881,712.2	11,224,699.3
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		250,429,244.6	289,059,544.7
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		250,388,593.1	289,018,893.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		91,822,409.3	92,488,066.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		38,477,868.1	40,135,777.4
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		7,440,385.5	10,276,900.2
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		46,478,143.4	79,518,471.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		66,169,786.8	66,599,677.6
52	Хяналтын бус хувь оролцоо		40,651.5	40,651.5
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		260,385,364.9	309,278,411.3

### 2.2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		138,227,033.1	167,898,070.6
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		12,399,515.4	16,531,193.7
110	Орлогын албан татвар		8,461,050.7	10,664,231.7
1100	Хувь хүний орлогын албан татвар		9,517,717.3	11,517,628.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-1,056,666.6	-853,396.7
113	Хөрөнгийн албан татвар		1,176,676.9	1,305,581.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		2,761,787.8	4,561,380.5
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	107,977,976.8	136,833,080.4
120	Нийтлэг татварын бус орлого		26,566,412.0	36,767,637.4
121	Хөрөнгийн орлого		112,593.0	232,119.5
122	Тусламжийн орлого		189,764.5	3,081.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв		81,109,207.3	99,830,242.3

	хоорондын шилжүүлэг			
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		17,849,540.9	14,533,796.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	106,178,325.6	121,569,394.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		106,178,325.6	121,569,394.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		102,325,734.6	111,928,266.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		52,536,225.2	62,588,792.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		6,598,867.5	8,138,890.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		5,876,009.9	6,584,525.3
2104	Хангамж, бараа материалын зардал		2,881,671.1	3,452,168.2
2105	Нормативд зардал		4,364,193.7	4,559,739.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,138,177.0	762,511.5
2107	Томилолт, зочны зардал		361,457.4	164,692.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,080,695.5	5,936,816.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		22,488,437.5	19,740,130.7
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		720,121.4	490,006.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,132,469.6	9,151,120.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		32,048,707.5	46,328,676.6
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	37,055.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		38,996,566.4	13,861,677.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-6,947,858.9	32,504,054.8

### 2.3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	133,192,091.5	152,350,251.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	12,399,515.4	16,531,283.7
110	Орлогын албан татвар	8,461,050.7	10,664,321.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	9,517,717.3	11,517,718.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,056,666.6	-853,396.7
113	Хөрөнгийн албан татвар	1,176,676.9	1,305,581.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,761,787.8	4,561,380.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	884,802.6	1,003,404.9
1181	Газрын төлбөр	377,805.1	542,133.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,499,180.1	3,015,842.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,588,171.2	121,236,707.3
120	Нийтлэг татварын бус орлого	20,176,606.4	21,174,345.4
121	Хөрөнгийн орлого	112,593.0	232,119.5
122	Тусламжийн орлого	189,764.5	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	81,109,207.3	99,830,242.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,204,405.0	14,582,260.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	105,850,576.8	126,386,530.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,850,576.8	126,386,530.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	101,937,493.0	116,728,455.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	57,086,422.6	67,070,903.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,826,034.4	9,522,033.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,442,377.0	7,379,320.9
2104	Хангамж, бараа материалын зардал	14,522,462.4	14,560,126.0
2105	Нормативт зардал	4,576,619.1	5,415,335.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,114,948.3	996,682.0

2107	Томилолт, зочны зардал	351,492.2	157,968.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,225,006.4	5,232,667.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,792,130.6	6,393,418.8
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	720,121.4	490,006.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,192,962.4	9,168,068.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	27,341,514.8	25,963,720.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	4,453.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	23,681,860.5	21,711,551.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,681,860.5	21,711,551.3
2200	Дотоод эх үүсвэрээр	23,681,860.5	21,711,551.3
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-23,681,860.5	-21,707,097.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,874,005.4	-1,140,335.4
14	Бусад эх үүсвэр	100,000.0	542,629.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,392,382.2	1,471,200.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	581,623.2	211,765.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,785,648.9	3,116,288.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,871,987.5	8,657,636.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,657,636.4	11,773,924.4

#### 2.4. Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,954,442.0	240,954,442.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	27,692,303.4	27,692,303.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	268,646,745.4	268,646,745.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,849,263.6	-2,849,263.6
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-9,141,925.8	-9,141,925.8
7	Өмчид гарсан өөрчлөлт	749,321.5	749,321.5
8	Зарласан ногдол ашиг	-27,774.0	-27,774.0
9	Тайлант үеийн үр дүн	-6,947,858.9	-6,947,858.9
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	250,429,244.6	250,429,244.6
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	250,429,244.6	250,429,244.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,170.2	1,170.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	250,430,414.8	250,430,414.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	429,890.8	429,890.8
17	Өмчид гарсан өөрчлөлт	5,737,084.2	5,737,084.2
18	Зарласан ногдол ашиг	-41,900.0	-41,900.0
19	Тайлант үеийн үр дүн	32,504,054.8	32,504,054.8
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	289,059,544.7	289,059,544.7

### 3. АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт юм.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 01-аас 2021 оны 04 дүгээр сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитор Б.Давааням, С.Гансүх, Л.Мандахнаран нар гүйцэтгэв.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дүгээр сарын 31-ний өдрийн 1/703 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

#### **Эрхэм зорилго:**

2020 он бол аймгийн Засаг даргын зүгээс 2016-2020 онд хэрэгжүүлэхээр баталсан “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэх сүүлийн буюу 4 дэх жил байлаа. 2020 оныг “Зүтгэл-Итгэл-Санаачилга”-ыг дэмжих жил болгон зарласан байна. Аймгийн Засаг дарга, МУ-ын Ерөнхий сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргатай 2020 онд хамтрах ажиллах гэрээ байгуулж ажилласан ба гэрээний биелэлт 98.6 хувьтай байна.

#### **Үйл ажиллагааны чиглэл:**

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ❖ Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагаар хангах
- ❖ Нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх, түүний хэрэгжилтийг хангаж ажиллах
- ❖ Орон нутгийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх
- ❖ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- ❖ Байгаль орчны нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулах, ойжуулалт
- ❖ Сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах
- ❖ Эмнэлгийн тусламж үйлчилгээ хүргэх
- ❖ Сургуулийн өмнөх боловсрол олгох
- ❖ Соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх
- ❖ Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих
- ❖ Биологийн төрөл зүйлийн хамгаалалт
- ❖ Нийгмийн халамж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- ❖ Хүүхдийн хөгжил хамгаалал
- ❖ Мал аж ахуйг хөгжүүлэх
- ❖ Хот байгуулалт, тохижилт, хөрөнгө оруулалт

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд орсон өөрчлөлтийг тухай бүрд нь мөрдөж ажиллаж байна.

Сангийн сайдын 2019 оны 173 дугаар тушаалаар программ хангамжийг хөгжүүлэх, мэдээллийн сан үүсгэх төрийн албаны цалингийн нэгдсэн системийг хөгжүүлэх үүрэг өгсөн ба 2020 оны 9 дүгээр сарын 1-ээс эхэлж хэрэгжсэн ба Хөвсгөл аймгийн төсөвт байгууллагууд 100 хувь хамрагдсан байна. Тус нэгдсэн системд хамрагдсанаар дараах давуу болон сул тал үүссэн байна.

#### **Давуу тал:**

1. Цалин, нэмэгдэл урамшуулалтай холбоотой зардлыг эдийн засгийн ангиллаар хянах боломжтой
2. Ажилтан бүр цалингийн мэдээллийг сар бүр хувийн цахим хаягаар хүлээн авах боломжтой болсон

#### **Сул тал:**

1. Цалингийн сангийн үлдэгдэл хүрэлцэхгүй байхад зарлагын гүйлгээний төлбөрийн хүсэлтийг хүлээн авч байна.
2. Нийгмийн даатгал, Татварын цахим системтэй холбогдоогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж аймгийн Засаг даргын 2019 оны А/375 тоот захирамжаар баталж мөрдсөн ба төрийн аудитын байгууллагаас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу өөрчлөлт оруулж аймгийн Засаг даргын 2020 оны А/552 тоот захирамжаар баталгаажуулсан байна.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дараах байдалтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69.2-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана” гэж заасны дагуу аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт аудитын алба нь сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчид болон санхүүгийн албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

- ❖ Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 4.3-т заасны дагуу Аймгийн Засаг даргын 2020.01.29-ний өдрийн А/41 захирамжаар 2020 онд хэрэгжүүлэх хяналтын ажлын төлөвлөгөөг батлуулсан байна. Хяналтад 8 сумын төрийн санг хамруулахаар төлөвлөсөн ба төлөвлөсөн сумдад хяналтыг 100 хэрэгжүүлэн ажилласан ба өдөр тутмын хяналтыг цахим хэлбэрээр хэрэгжүүлж байна.
- ❖ Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019 онд 124 байгууллага, аж ахуйн нэгжид дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан ба тайлант хугацаанд 142 байгууллагад хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Хяналт шалгалтаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллаж байгаа талаар ажлын тайланд бичсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын хугацаанд хэрэгжүүлсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийн төлөвлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн эргэн төлөлт, улс, орон нутаг, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн эргэн төлөлтөөс орох орлого бүрдүүлэлттэй холбоотой нийт **19,517.7** сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байгаагаас харахад дээрх хяналтуудын үр нөлөө хангалтгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрсдэлийг оновчтой тогтоож, эрсдэлийг хаах бодлого боловсруулж, оновчтой шийдвэрт гаргахад нөлөөлж чадахгүй байна.

### 3.4 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн *нийт зардлын дүнг* сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 144,846.2 сая төгрөгийн 2 хувь буюу 2,896.9 сая төгрөгөөр тогтоож баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2,708.8 сая төгрөгөөр тогтоосон нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар тооцсонтой холбоотой болно. Төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг төвшнөөс 188.1 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,657.6 сая, эцсийн үлдэгдэл 11,773.9 сая төгрөг болж, 3,116.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	13.1	21.1	8.0
Банканд байгаа бэлэн мөнгө	8,644.5	11,752.8	3,108.3
Дүн	<b>8,657.6</b>	<b>11,773.9</b>	<b>3,116.3</b>
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,506.8	1,906.7	-600.1
Төсөл/ сан	3,375.1	3,881.3	506.2

Төрийн сан	2,304.2	5,358.2	3,054.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	471.6	627.8	156.2
<b>Дүн</b>	<b>8,657.6</b>	<b>11,773.9</b>	<b>3,116.3</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан  
Нийт мөнгөн хөрөнгийн 99.6 хувь нь харилцах дансанд, 0,18 хувь нь кассат байгаа бэлэн мөнгө эзэлж байна. Банканд байршиж буй 11,752.8 сая төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 21.1 сая төгрөг байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт мөнгөн хөрөнгийн 16,2 хувь, төсөл сангийн үлдэгдэл 32,9 хувь, төрийн сангийн үлдэгдэл 45,5 хувь, орон нутгийн өмчит компаниудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5,3 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь:

- Дэлхийн дахинд нүүрлэсэн Ковид -19 цар тахлын нөхцөл байдлаас болж орон нутгийн байгууллагуудын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө
- Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс давж биелсэн мөнгөн хөрөнгө

### Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,167.6 сая, эцсийн үлдэгдэл 11,125.1 сая төгрөг болж, 2,957.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Төрийн сан, арилжааны банкны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	8,167.6	11,125.1	2,957.5
Арилжааны банк	458.4	606.7	148.3
Гадаад валют	18.5	21,1	2.6
<b>Нийт дүн</b>	<b>8,644.5</b>	<b>11,752.8</b>	<b>3,108.4</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн мөнгөн хөрөнгийн данстай холбоотой материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй болно.

### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансаар ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 6,471.6 сая, эцсийн үлдэгдэл 7,171.2 сая төгрөг болж, 699.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+, бууралт-
Ажиллагчидтай холбогдсон авлага	39.1	56.9	17.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	19.6	14.5	-5.1
Татаас, санхүүжилтийн авлага	0	0	0
Зээлийн хүүгийн авлага	180.8	202.9	22.1
Дансны авлага /ТӨҮГ/	1,230.6	2,076.3	845.7
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	11.4	126.5	115.1
Байгууллагаас авах авлага	1,119.1	1,246.6	127.5
Хувь хүмүүсээс авах авлага	132.5	262.3	129.8
Хувь хүмүүст олгосон зээл	3,738.6	3,185.1	-553.5
<b>Нийт дүн</b>	<b>6,471.7</b>	<b>7,171.2</b>	<b>699.6</b>
Үүнээс: байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	4,200.6	3,640.5	-560.1
Төсөл/ сан	839.2	1,123.2	284.0
Төрийн сан	0	0	0
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,431.8	2,407.6	975.6
<b>Нийт дүн</b>	<b>6,471.6</b>	<b>7,171.2</b>	<b>699.6</b>

Эх сурвалж: /Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Дансны авлага нэмэгдсэн нь дараах шалтгаантай байна. **Тухайлбал:**

- Цагаан-уул сумын Засаг дарга, “Идэр нумт” ХХК-тай байгуулсан гэрээ маргаантай байдал адгуулсаар байгаа тул тайлант онд “Галт дулаан” ХХК-аас “Идэр нумт” ХХК-д шилжүүлсэн 320.1 сая төгрөгөөр дансны авлага нэмэгдсэн байна.

- “Хөвсгөл Эрчим” хүч ХХК-ийн авлага 538.1 сая төгрөгөөр нэмэгдсэн ба түүнд цахилгаан бичилтийн циклийг сарын 15-аар тасалбар болгож, нөгөө талаас цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор 2020.12.01-ээс цахилгаан эрчим хүчний үнийг хөнгөлөх шийдвэр гаргасантай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлага дансанд 200.7 сая төгрөгийг хоорондын тооцоогоор дамжуулан устгах бичилт хийсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

1. Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлага данстай холбоотой нийт 1,161.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба эдгээр нь он удаан жил болсон авлагыг шийдвэрлээгүй, сум хөгжүүлэх сангийн авлагыг урт болон богино хугацаагаар нь зөв ангилаагүй гэх мэт шалтгаантай байна. Дээрх зөрчлийг арилгах зөвлөмжийг аудитаар холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилласан байна.
2. Авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн 447 иргэнтэй холбоотой 2,268.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна. /Хавсралт/ Энэ нь дараах шалтгаантай байна. Үүнд:
  - Иргэдэд сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгож байгаа зээлийн хэмжээ бага, ажлын байр нэмэгдүүлж, бизнес эрхлэх эх үүсвэр болж чадахгүй байгаагаас зээлийн эргэн төлөлт удаашралтай байна.
  - Нөгөө талаас арилжааны банкны зээлийн хүү хэт өндөр байгаагаас иргэд сум хөгжүүлэх сангаас янз бүрийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төсөл бичиж зээл авч байгаа ч бодит байдал дээр өрхийн хэрэгцээнд зарцуулж байна.
  - Сум хөгжүүлэх сангаас зээл олгох “Зөвлөл”-өөр шаардлага хангасан төсөл арга хэмжээг санхүүжүүлээгүй, сонгон шалгаруулалтыг журам зааврын дагуу хийхгүй байгаагаас зээлийн эргэн төлөлт удааширч, эзэн холбогдогчгүй болох гэх мэт асуудлууд үүсэж байна.

**3.5.4 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 8.2 сая, эцсийн үлдэгдэл 104.7 сая төгрөг болж, 96.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+, бууралт-
Урьдчилж гарсан зардал	7.9	100.8	92.9
Урьдчилгаа тооцоо	0.3	3.9	3.6
<b>Нийт дүн</b>	<b>8.2</b>	<b>104.7</b>	<b>96.5</b>

Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	0.3	5.7	5.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	7.9	99.0	91.1
<b>Дүн</b>	<b>8.2</b>	<b>104.7</b>	<b>96.5</b>

*Эх сурвалж: /Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/*

Тайлант онд урьдчилгаа дансны үлдэгдэл 96.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь “Могойн гол” ХК-ийн уулын өрмийн машины хошуу худалдан авахад 70.0 сая төгрөг, уулын ажлын техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад 26.1 сая төгрөгийг урьдчилан олгосонтой холбоотой байна. Тус данстай холбоотой материаллаг хэмжээний алдаа зөрчил илрээгүй болно.

**3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт**

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл **1,351.7** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **2,066.95** сая төгрөг болж, **715.3** сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №8 Урт хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт /+/, бууралт /-/
Хувь хүмүүст олгосон зээл	1,329.2	2,047.9	718.7
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	22.5	19.1	-3.4
<b>Нийт дүн</b>	<b>1,351.7</b>	<b>2,067.0</b>	<b>715.3</b>

Үүнээс: байгууллагын төрлөөр	0.0	0.0	0.0
Төсөвт байгууллага	1,351.7	2,067.0	715.3
<b>ДҮН</b>	<b>1,351.7</b>	<b>2,067.0</b>	<b>715.3</b>

Эх сурвалж: /Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг урт болон богино хугацаат гэж ангилсны улмаас үүссэн зээлийн авлагыг хуримтлуулан бүртгэсэн болно.

**Аудитын илрүүлэлт:** Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар тус данстай холбоотой 188.1 сая төгрөгийн алдаа илэрч аудитын хугацаанд бүрэн залруулж ажилласан байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 14,667.7 сая, эцсийн үлдэгдэл 19,131.6 сая төгрөг болж, 4,463.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+, бууралт-
Тусгай зориулалттай материал	815.5	906.6	91.1
Эм боох материал	419.2	673.9	254.7
Дуусаагүй үйлдвэрлэл	10.3	598.0	587.7
Бэлэн бүтээгдэхүүн	2,384.5	2,862.5	478.0
Бичиг хэргийн материал	215.6	376.1	160.5
Аж ахуйн материал	2,671.2	3,598.2	927.0
Сэлбэг хэрэгсэл	755.8	627.0	-128.8
Түлш, шатах тослох материал	769.7	1,042.1	272.4
Барилгын засварын материал	265.7	283.5	17.8
Хүнсний материал	724.4	764.0	39.6
Бусад хангамжийн материал	5,301.6	7,074.6	1,773.0
Мал амьтад	334.1	325.1	-9.0
<b>Нийт дүн</b>	<b>14,667.7</b>	<b>19,131.6</b>	<b>4,463.0</b>
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,799.1	2,193.4	394.3
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	1,799.1	2,193.4	394.3
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	10,342.3	13,926.6	3,584.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,325.4	5,205.0	879.6
<b>Нийт дүн</b>	<b>14,667.7</b>	<b>19,131.6</b>	<b>4,463.9</b>
<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>166.5</b>	<b>236.1</b>	<b>69.6</b>
Тэжээлийн нөөц	166.5	224.7	58.2
Барааны нөөц	0	11.4	11.4

Эх сурвалж: /Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Тайлант онд бараа материалын дансанд 25,392.0 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэний 22,573.1 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 555.2 сая төгрөгийн бараа материалыг хандиваар, 279.1 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан, 1,984.5 сая төгрөгийн бараа материалыг бусад шалтгаанаар олж авсан байна. Харин тус данснаас 20,928.1 сая төгрөгийн бараа материал хасагдсаны 18,885.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан, 2,042.7 сая төгрөгийг бараа материалыг шилжүүлсэн ба холбогдох байгууллагын шийдвэрээр акталж устгасан байна.

Бараа материалын үлдэгдэл их хэмжээгээр нөөцлөгдөж байгаагийн шалтгаан нь дараах байдалтай байна. Үүнд:

- Хичээлийн шинэ жилийн цаглавар санхүүгийн тайлангийн цаглавартай зөрүүтэй, нөгөө талаас цар тахал нөхцөл байдлаас шалтгаалан 2020 онд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг хязгаарласан тул ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол, цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал, хичээл практикийн материал, түлээ зэрэг бараа материалыг тодорхой хэмжээнд нөөцөлж байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС, гадаадын төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 2,193.4 сая төгрөгийн хөрөнгийг бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:** Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материал данстай холбоотой нийт 93.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 45.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 48.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж шийдсэн болно.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл **227,262.9** сая, эцсийн үлдэгдэл **266,610.5** сая төгрөг болж, **39,347.6** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+,бу уралт-
<b>Биет хөрөнгө</b>	<b>207,305.7</b>	<b>246,569.8</b>	<b>39,264.1</b>
Барилга, байгууламж, орон сууц	186,014.8	220,106.4	34,091.6
Хуримтлагдсан элэгдэл	(17,096.7)	(23,174.1)	(6,077.4)
Авто-тээврийн хэрэгсэл	10,737.3	11,993.0	1,255.7
Хуримтлагдсан элэгдэл	(6,139.4)	(7,025.4)	(886.0)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	22,057.9	25,335.1	3,277.2
Хуримтлагдсан элэгдэл	(14,847.9)	(16,360.1)	(1,512.2)
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,660.1	8,496.7	809.6
Хуримтлагдсан элэгдэл	(4,291.7)	(4,852.3)	(560.6)
Зам, гүүрний байгууламж	10,981.2	11,330.2	349.0
Хуримтлагдсан элэгдэл	(1,253.9)	(2,287.6)	(1,033.7)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,317.0	1,317.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	13,020.4	16,386.4	3,366.0
Хуримтлагдсан элэгдэл	(3,290.7)	(4,561.8)	(1,271.1)
Дуусаагүй барилга, байгууламж	253.9	7,620.9	7,367.0
Ном	2,183.3	2,272.4	89.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>19,957.2</b>	<b>20,040.7</b>	<b>83.5</b>
Программ хангамж	706.5	796.7	90.2
Хуримтлагдсан элэгдэл	(332.6)	(378.8)	(46.1)
Бусад биет бус хөрөнгө	20,135.6	20,208.3	72.8
Хуримтлагдсан элэгдэл	(552.2)	(585.5)	(33.3)
<b>Нийт дүн</b>	<b>227,262.9</b>	<b>266,610.5</b>	<b>39,347.6</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	172,658.0	199,392.4	26,734.4
Төсөл/ сан	11.3	8.98	-2.3
Төрийн сан	0	0	0
ТӨҮГ болон ОНӨҮГ	54,593.5	67,209.1	12,615.6
<b>Дүн</b>	<b>227,262.9</b>	<b>266,610.5</b>	<b>39,347.6</b>

Эх сурвалж: /Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 2,471.7 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 7,601.2 сая төгрөг, хандиваар авсан 3,101.1 сая төгрөг, бусад буюу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж бүртгэлд тусгасан 41,708.3 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдлээр 1,118.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 1,714.9 сая төгрөг, акталсан 1,273.7 сая төгрөг, худалдсан 48.3 сая төгрөг, бусад 533.1 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 1,652.8 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 7,620.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн байгаа ба үүний 7,394.9 сая төгрөгийн ажил нь “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ний дансанд үлдэгдэлтэй байна. Үүнд:

Хүснэгт №7 Дуусаагүй барилга дансны үлдэгдлийн шалтгаан тайлбар

№	Төсөл арга хэмжээний нэр	Дансны үнэ /сая төг/	Шалтгаан	Байгууллагын нэр
1	Хөвсгөл Эрчим хүч ХХК өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	199.1	Цар тахалтай холбоотой хийгдэх ажлууд хойшилсон байна.	“Хөвсгөл Эрчим Хүч” ХХК

4	Арьс ширний үйлдвэрийн тоног төхөөрөмж	15.0	Үйлдвэрийн барилгын асуудал шийдэгдээгүй	“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК
5	Халуун усны барилга	11.9	Газар нь цөвдэгтэй тул ашиглах боломжгүй байна.	“Могойн гол”
6	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл	7,394.9	Төсөл арга хэмжээ хэрэгжих шатандаа явж байгаа. /Цэвэрлэх байгууламж/	Хөвсгөл ус суваг ХХК
6	<b>Нийт дүн</b>	<b>7,620.9</b>		

#### Аудитын илрүүлэлт:

- Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгө данстай холбоотой нийт 1,377.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба биет хөрөнгөтэй холбоотой 1,194.5 сая төгрөгийн, биет бус хөрөнгөтэй холбоотой 183,3 сая төгрөгийг зөрчил илэрч, 16.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,361.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж ажилласан болно.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа хөрөнгийн түүвэрлэх хянахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 12,078 ширхэг 6,264.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна. Энэ УСНББОУС-17 параграф 49, УСНББОУС-31 параграф 78, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т “Биет хөрөнгийн дансны бодит үнээсээ материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ” гэж заасантай нийцэхгүй байгаа ба “үнэлгээ, хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл **9,956.1** сая, эцсийн үлдэгдэл **20,218.7** сая төгрөг болж, **10,262.6** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+,б ууралт-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,074.4	8,994.2	2,919.8
Богино хугацаат зээлийн өглөг	56.1	336.3	280.2
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	56.1	336.3	280.2
Өглөг	1,364.2	8,503.2	7,139.0
Ажилчидтай холбогдсон өглөг	30.6	32.0	1.4
Бараа үйлчилгээний зардлын өглөг	853.9	636.8	-217.1
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	0.0	0	0
Зээлийн хүүгийн өглөг	479.7	475.9	-3.8
Бусад өглөг	4,639.2	7,418.3	2,779.1
Байгууллагад төлөх өглөг	3,141.3	5,373.5	2,232.2
Хувь хүмүүст төлөх өглөг	34.3	23.9	-10.4
Татварын өглөг /ТӨҮГ/	334.5	490.4	155.9
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	68.3	122.1	53.8
Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/	490.0	480.0	-10.0
Дансны өглөг /ТӨҮГ/	570.9	928.2	357.3
Урьдчилж орсон орлого	14.9	154.7	139.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	14.8	19.7	4.9
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	0.0	0.2	0.2
Бусад урьдчилж орсон орлого	0.1	134.8	134.7
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,881.7	11,224.7	7,343.0
Урт хугацаат зээл	3,881.7	11,224.7	7,343.0

Хувь хүмүүсийн зээл	108.5	108.2	-0.3
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	2,933.8	2,885.8	-48.0
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	839.4	8,230.8	7,391.4
<i>Нийт дүн</i>	<i>9,956.1</i>	<i>20,218.9</i>	<i>10,262.8</i>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,263.0	1,304.9	41.9
Төсөл, сан	2,543.6	3,450.4	906.8
Төрийн сан	108.5	108.3	-0.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	6,041.0	15,355.3	9,314.3
<b>ДҮН</b>	<b>9,956.1</b>	<b>20,218.9</b>	<b>10,262.8</b>

Эх сурвалж: /Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын өр төлбөр 9,314.3 сая төгрөгөөр нэмэгдсэн ба богино хугацаат өр төлбөр 2,919.8 сая төгрөгөөр, урт хугацаат өр төлбөр 7,343.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. **Өр төлбөр нэмэгдсэн шалтгаан нь:**

- Засгийн газрын 2020 оны 78, 168, 114 дүгээр тогтоолоор цар тахалтай холбоотой бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн, төсвийг үр ашигтай удирдан зохион байгуулах чиглэл өгч, ажилласантай холбоотой авсан арга хэмжээний хүрээнд зарим зардлын зарцуулах эрхийг 12 дугаар сарын 25-аас хойш нээсэн, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 2 хувиар бууруулж олгосон нь өр төлбөр үүсэх шалтгаан болсон байна.
- Барьцаа хөрөнгийн данс 3,395.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь богино хугацаат өр төлбөр тайлант онд нэмэгдэх шалтгаан болсон байна.
- Хөвсгөл аймгийн Засаг дарга, Сангийн яамтай байгуулсан MON7313 гэрээний дагуу 7,394.9 сая төгрөгөөр Хөвсгөл аймагт цэвэрлэх байгууламж барьж байгаа ба ажлын гүйцэтгэл нь 80 гаруй хувьтай байна. Тус гэрээний дүнг орон нутгийн төсвөөс төлж барагдуулах гэрээ хийсэн тул тус гэрээний дүнгээр урт хугацаат өр төлбөр нэмэгдэх шалтгаан болсон байна.

#### **Урт хугацаат өр төлбөрийн талаар:**

- Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн өр төлбөр 1,008.5 сая төгрөг, “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 1,877.3 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба энэ нь Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны төслийн зээлийн үлдэгдэл байна. Тайлант онд Хөвсгөл Эрчим хүч ХХК-аас зээлийн төлбөрт 48.3 сая төгрөг, хүүгийн төлбөрт 7.8 сая төгрөгийг төлсөн байна. Харин “Хөвсгөл ус суваг” ХХК тайлант онд зээлийн төлөлт хийгээгүй байна.
- 2003-2010 онд хэрэгжсэн “Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр”-ийн зээлийн үлдэгдэл 108.5 сая төгрөг байна. Тайлант онд зээлийн төлбөрт 0.3 сая төгрөгийг төлж барагдуулсан байна.
- Мөрөн сумын “Сум хөгжүүлэх сан”-аас 2018 онд авсан “Хоймор нутгийн чулуу” ХХК-ийн зээлийн үлдэгдэл 40.9 сая төгрөг байгаа бөгөөд тайлант онд төлөлт хийгээгүй байна.
- MON7313 гэрээний дагуу 7,394.9 сая төгрөгөөр Хөвсгөл аймагт цэвэрлэх байгууламж барьж байгаа ба дээрх дүнгээр урт хугацаат өр төлбөр нэмэгдсэн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар өр төлбөр данстай холбоотой нийт 183.3 сая төгрөгийн зөрчил илэрч, өр төлбөрийг барагдуулах, холбогдох газарт асуудал тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг төсөв захирагч нарт хүргүүлэн ажилласан байна.
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өр төлбөр дансанд Цагаан-уул сумын “Галт дулаан” ХХК-ийн дулааны шугам сүлжээ, зуухны шинэчлэлийн ажлын гэрээний дүнг ашиглагч, гүйцэтгэгч нарын маргаанаас болж шийдвэрлээгүй байгаа тул 2020 оны санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 2,919.8 сая төгрөгөөр буюу 48.1 хувиар, урт хугацаат өр төлбөр 7,343.0 сая төгрөгөөр буюу 189.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх

заалттай нийцэхгүй байгаа ба “Үнэн ба зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн, өр төлбөрийг барагдуулж, нэмж өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл **250,429.2** сая төгрөг, эцсийн үлдэгдэл **289,059.5** сая төгрөг болж, **38,630.3** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №10 Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+, бууралт-
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	91,822.4	92,488.1	665.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	38,477.9	40,135.8	1,657.9
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	7,440.4	10,276.9	2,836.5
Хуримтлагдсан үр дүн	46,478.1	79,518.5	33,040.4
<b>Өмнөх үеийн үр дүн</b>	<b>53,426.0</b>	<b>47,014.4</b>	<b>(6,411.6)</b>
<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>-6,947.9</b>	<b>32,504.1</b>	<b>39,451.9</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,169.8	66,599.7	429.9
Хяналтын бус хувь оролцоо	40.7	40.7	0.0
<b>Нийт дүн</b>	<b>250,429.2</b>	<b>289,059.5</b>	<b>38,630.3</b>

Эх сурвалж: /Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Засгийн газрын хувь оролцоо дансны өөрчлөлтөд гол нөлөө үзүүлсэн байна. **Үүнд:**

- Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж дууссан барилга байгууламж, тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлд тусгаснаар тайлант үеийн үр дүн 32,504.1 сая төгрөгийн үр дүнтэй гарсан нь засгийн газрын хувь оролцоо дансны дүн нэмэгдэх шалтгаан болсон байна.

Аудитаар тухайн данстай холбоотой асуудалтай зүйл ирээгүй байна.

### 3.5.10 Орлогын данс

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 167,898.1 сая төгрөгийг орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 29,762.1 сая төгрөг буюу 21,5 хувиар өссөн байна. Орлогын үзүүлэлтийг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өссөн, буурсан
<b>Татварын орлого</b>	12,399.5	16,531.2	4,131.7
<b>Татварын бус орлого</b>	107,978.0	136,833.1	28,855.1
<b>Тусламж, санхүүжилтийн орлого</b>	17,849.5	14,533.8	(3,315.7)
<b>Нийт орлого</b>	<b>138,227.0</b>	<b>167,898.1</b>	<b>29,671.0</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Өмнөх оноос орлого нэмэгдэх болсон шалтгааны харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

1. Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 101 дүгээр тогтоол, аймгийн ИТХТ-ийн 2020 оны 56 дугаар тогтоолоор гарсан шийдвэрийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад хүлээн авсан 29 нэр төрлийн 32,416.3 сая төгрөгийн барилга байгууламжийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.
2. Орон нутгийн байгууллагуудын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 4,178.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.
3. Тайланд онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг нийт 6 суманд төлөвлөсөн хэмжээнээс 1,395.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

### Аудитын илрүүлэлт:

1. Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар орлогын данстай холбоотой 1,032.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч

- холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлж ажилласан.
- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж байгаа боловч, татварын орлогын ногдуулалтыг хийж, орлогыг аккурэл сууриар бүртгэхгүй байгаагаас орлоготой холбоотой үүссэн өр, авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байна.
  - Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд татварын бус орлогоос борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бууруулах байдлаар тайлагнасан нь татварын бус орлогыг буруу илэрхийлэхэд хүргэсэн байна. **Тухайлбал:** Их-уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд татварын бус орлогын дүн -65.5 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

### 3.5.11 Зардлын данс

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд нийт 121,569.4 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргасан байна. Үүнд: *Хүснэгт№-12: Санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулсан судалгаа.*

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Хувь
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	106,178.3	121,569.4	15,391.1	114,5
УРСГАЛ ЗАРДАЛ	106,178.3	121,569.4	15,391.1	114,5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,325.7	111,928.3	9,602.5	109,4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,536.2	62,588.8	10,052.6	119,1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,598.9	8,138.9	1,540.0	123,3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,876.0	6,584.5	708.5	112,1
Хангамж, бараа материалын зардал	2,881.7	3,452.2	570.5	119,8
Норматив зардал	4,364.2	4,559.7	195.5	104,5
Эд хогшил, урсгал засварын зардал	1,138.2	762.5	(375.7)	67,0
Томилолт, зочны зардал	361.5	164.7	(196.8)	45,6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,080.7	5,936.8	(143.9)	97,6
Бараа үйлчилгээний бусад зардал	22,488.4	19,740.1	(2,748.3)	87,8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,132.5	9,151.1	6,018.7	292,1

**Эх сурвалж:** *Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан*

Тайлант онд гарсан нийт зардлыг өмнөх онтой харьцуулбал 15,391.1 төгрөгөөр буюу 114.5 хувиар нэмэгдсэн байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал нийт 10,052.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ шинэчлэгдсэн, Төрийн албаны тухай хууль шинэчлэн баталж мөрдсөнтэй холбоотой төрийн үйлчилгээний албан хаагчдад ажилсан жилийн нэмэгдэл олгосонтой холбоотой нэмэгдсэн байна.
- Дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотой Засгийн газар, Сангийн яамнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд зарим зардлын зарцуулах эрхийг оны төгсгөлд нээсэнтэй холбоотой гүйгээ хийгдэж амжаагүйтэй холбоотой урсгал шилжүүлгийн зардал тайлант онд нэмэгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой 260.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлж ажилласан.
- Төсөвт байгууллагын түлш халаалтын зардал, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн /нэгдсэн халаалтай газруудад/ борлуулалтын орлого хооронд устгах бичилт хийж байгаа нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн түлш халаалтын дүнг буруу илэрхийлэхэд хүргэж байна. **Тухайлбал:** Тариалан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн түлш халаалтын зардал 636,0 сая төгрөг байхад хоорондын тооцоо хийсний дараах түлш халаалтын зардлын дүн 80.8 сая төгрөг болж бууруулж харагдаж байна.

### 3.6 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 24 төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, 180 төсвийн байгууллага, 25 төрийн сан, 49 орон нутгийн тусгай сан, 22 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 1 төсөл, хөтөлбөр, 6 хөрөнгө оруулалтын болон бусад данс, нийт 307 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагаас 2021 онд хэрэгжүүлсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах байгууллагууд зөрчилтэй дүгнэлт авсан байна. **Үүнд:** “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг 4, “Сөрөг” санал дүгнэлтийг 2 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хүргүүлсэн бай бусад дүгнэлт гаргасан байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт хүргүүлсэн байна. Үүнийг байгууллагаар нь харуулбал:

№	Байгууллагын нэр	Санал дүгнэлтийн төрөл
1	Арбулаг сумын ЗДТГ	Хязгаарлалттай
2	Түнэл илч ОНӨҮГ	Хязгаарлалттай
3	Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч	Хязгаарлалттай
4	Алаг-эрдэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч	Хязгаарлалттай
5	“Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан” ХК	Хязгаарлалттай
4	Алаг-эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль	Сөрөг
5	Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургууль	Сөрөг

Аудитад хамрагдаагүй байгууллага, аж ахуйн нэгж байхгүй байна.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй зүйл илрээгүй тул залруулга хийгдээгүй болно.

#### Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн санал, зөвлөмж:

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 4,025.9 сая төгрөгийн зөрчил үлдсэн ба үүнээс материаллаг хэмжээний залруулагдаагүй 1,049.8 сая төгрөгийн зөрчил байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид дотоод хяналт, шилэн данс, тусгай сангийн үйл ажиллагаа, харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, үндсэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой 360.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид 1 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлж, дараагийн аудитаар авч үзэх 4 асуудал, дээд шатны байгууллагын анхааралд 2 асуудлыг хандуулж байна.

#### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 24 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан ба Алаг-эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт гаргаж, бусад төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй санал дүгнэлт хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 5,336.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,739.5 сая төгрөгийн алдааг залруулж, сахилгын арга хэмжээ авах 2 албан шаардлага хүргүүлж, 1,597.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө. Үүнд:

- Цагаан-үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 3,210.6 сая төгрөгийн хоорондын тооцоог хийж, устгаагүй байсныг аудитаар залруулсан.
- Бусад залруулах боломжгүй зөрчилд дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох төсөв захирагч нарт хүргүүлсэн болно.

### **Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар**

Аудитаар нийт 178 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, 3 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 60 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 115 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж ажилласан байна. Алаг-эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль, Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт, Арбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт хүргүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль журмын хэрэгжилттэй холбоотой 5,147.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,830.5 сая төгрөгийн алдааг залруулж, 69.5 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 157.1 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 2,090.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

### **Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа орон нутгийн өмчит 24 аж ахуйн нэгж байгууллагаас 9 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 15 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд санал дүгнэлт хүргүүлж ажилласан. **Үүнээс:** 14 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” /Хөвсгөлийн эмийн эргэлтийн сан ХК/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 171.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 59.3 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулж, 16.7 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 95,2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

### **Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 47 тусгай сангийн санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 2 сангийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан байна. Орон нутгийн тусгай сангийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт хүргүүлсэн байна.

Аудитаар сум хөгжүүлэх олгосон зээлийн хөрөнгөөр олгосон зээлийн эргэн төлөлтөөс 2,268.8 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байдалтай байна. Үүнийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн анхааралд хандуулах шийдвэрийг гаргаж ажилласан болно.

### **Төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 1 төсөл хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж аудитад хамруулсан болно.

## **3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 135 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар төсөв захирагч нарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг нягтлан бодох бүртгэлтэй тулган хянаж үзэхэд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 1,646.4 сая төгрөгийн зөрчил, төсвийн шууд захирагч болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар 5,956.7 сая төгрөгийн зөрчил илэрч тухайн шатны төсөв захирагчид Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр журмын холбогдох заалтыг заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтын дагуу хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангахгүй байгаа төсвийн захирагч нарт хариуцлагын арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. /Хавсралт№-3/

## **3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 4 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлснээс, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож үзэхэд 75 хувь байна.

## **3.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж байгаа боловч, татварын орлогын ногдуулалтыг хийж, орлогыг аккурэл сууриар бүртгэхгүй байгаагаас орлоготой холбоотой үүссэн өр, авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байна.
2. Орон нутгийн хөрөнгө оруулалтад нийт 1,736.4 сая төгрөгийн төлөвлөгөөг баталсан бөгөөд 837.0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, урсгалд зардалд зарцуулахаар хуваарилж, гүйцэтгэлийг хангуулсан байна. Үүнийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд хэрэгжүүлэх “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”-д хийх гүйцэтгэлийн аудитаар нягтлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.
3. Хөвсгөл аймгийн Засаг дарга, Хөгжлийн банкттай 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр 2/69 тоот гэрээг байгуулсан ба тус гэрээнд 5 жилийн хугацаатай 11,637.0 сая төгрөгийг **/үндсэн төлбөр нь 9,549.6 сая төгрөг, хүүгийн төлбөр нь 2,087.4 сая төгрөг/** буцаан төлөх гэрээ хийсэн байна. Гэтэл оршин суугчдаас гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл, хуваарь, барилгын чанар байдалтай холбоотой гарсан санал гомдлын дагуу аймгийн Засаг дарга 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/247 тоот албан бичгийг Хөгжлийн банканд хүргүүлсэн байна. Энэ асуудлыг шийдвэрлэж, хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайланд бүрэн тусгах нь зүйтэй байна.
4. Нийт 135 орон сууц түрээслэгчийн 14 түрээслэгч нь гэрээ байгуулж баталгаажуулсан ба 121 оршин суугчид нь ямар нэгэн гэрээ хийгээгүй байна.

#### **Дээд шатны байгууллагуудын анхааралд хандуулах асуудал:**

5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд татварын бус орлогоос борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бууруулах байдлаар тайлагнасан нь татварын бус орлогыг буруу илэрхийлэхэд хүргэсэн, төсөвт байгууллагын түлш халаалтын зардал, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн /нэгдсэн халаалтай газруудад/ борлуулалтын орлого хооронд устгах бичилт хийж байгаа нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн түлш халаалтын дүнг буруу илэрхийлэхэд хүргэж байна. Эдгээр нь Сангийн яамны Э-тайлан цахим программын алдаатай байдлаас шалтгаалсан байна.
6. Сумдын Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа ба үр дүнгийн урамшууллыг харилцан адилгүй тооцон авч байна. Энэ зөрчлүүд нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралттай нийцэхгүй байна. Сургуулийн өмнөх боловсролын бүтэц, орон тоо норм нормативыг тогтоож, орон нутагт гарч байгаа хүндрэл бэрхшээлийг шийдэх нь зүйтэй байна.

#### **3.10 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС, АОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

##### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд залруулагдаагүй нийт 4,386.5 сая төгрөгийн алдаа, зөрчлөөс материаллаг хэмжээний залруулагдаагүй 1,410.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 2,708.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 1,295.5 сая төгрөгөөр бага тул **“Зөрчилгүй”** дүгнэлтийг өгч байна.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

#### 4. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.1.1 **Илрүүлэлт:** Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын хугацаанд хэрэгжүүлсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийн төлөвлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн эргэн төлөлт, улс, орон нутаг, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн эргэн төлөлтөөс орох орлого бүрдүүлэлттэй холбоотой нийт 19,517.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байгаагаас харахад дээрх хяналтуудын үр нөлөө хангалтгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрсдэлийг оновчтой тогтоож, эрсдэлийг хаах бодлого боловсруулж, оновчтой шийдвэрт гаргахад нөлөөлж чадахгүй байна.

4.1.2 **Эрсдэл:** Төсвийн ерөнхийлөн захирагчийг эрсдэлээс урьдчилан сэргийлж чадахгүй байх, зөрчил дутагдал дахин давтагдах

4.1.3 **Өгсөн зөвлөмж:** Эрсдэлийг зөв тодорхойлж, дотоод хяналтыг оновчтой хэрэгжүүлэх

4.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна, цаашид хэрэгжүүлэн ажиллах болно.

##### 4.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

4.2.1 **Илрүүлэлт:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа хөрөнгийн түүвэрлэх хянахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 12,078 ширхэг 6,264.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна. Энэ УСНББОУС-17 параграф 49, УСНББОУС-31 параграф 78, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т “Биет хөрөнгийн дансны бодит үнээсээ материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ” гэж заасантай нийцэхгүй байгаа ба “үнэлгээ, хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 **Эрсдэл:** Биет болон биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцохгүй байгаагаас, нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлагнал нь холбогдох стандарт, журам, заавартай зөрчилдөх

4.2.3 **Өгсөн зөвлөмж:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний байгууллагуудын биет болон биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийг үнэлэх, тогтоох арга хэмжээ авч ажиллах

4.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна, цаашид хэрэгжүүлэн ажиллах болно.

##### 4.3 сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал

4.3.1 **Илрүүлэлт:** Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр

олгосон зээлийн авлагын үлдэгдэлд 2,268.8 сая төгрөгийн авлагын хугацаа хэтэрсэн ба өмнөх оноос 360.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ байдал нь сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт болон зарцуулалтад сөрөг нөлөөг үзүүлсээр байна. Эдгээр нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.3 дахь заалттай нийцэхгүй байгаа ба үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг эрсдэлд оруулах магадлал өндөр байна.

4.3.3 **Өгсөн зөвлөмж:** Сумын засаг дарга болон төсвийн төвлөрүүлэн захирагч нарт тодорхой чиглэл өгч, сум хөгжүүлэх сангаас зээл аваад хугацаа хэтэрсэн иргэдийн зээлийг төсөвт эргүүлэн оруулах талаар бодитой ажил зохион байгуулах, үр дүнг тооцон ажиллах

4.3.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна, цаашид хэрэгжүүлэн ажиллах болно.

#### 4.4 ӨР ТӨЛБӨРИЙН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.4.1 **Илрүүлэлт:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 2,919.8 сая төгрөгөөр буюу 48.1 хувиар, урт хугацаат өр төлбөр 7,343.0 сая төгрөгөөр буюу 189.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалттай нийцэхгүй байгаа ба “Үнэн ба зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өр төлбөр дансанд Цагаан-уул сумын “Галт дулаан” ХХК-ийн дулааны шугам сүлжээ, зуухны шинэчлэлийн ажлын гэрээний дүнг ашиглагч, гүйцэтгэгч нарын маргаанаас болж шийдвэрлээгүй байгаа тул 2020 оны санхүүгийн тайланд тусгагдаагүй байна. Гэхдээ тус хөрөнгийг тус аж ахуйн нэгж ашиглаж, үр ашгийг нь Цагаан-уул сумын иргэд хүртэж байна.

4.4.2 **Эрсдэл:** Төсвийн үр ашигтай байдал алдагдаж, төсвийн тэнцвэр алдагдах сөрөг үр нөлөө бий болох

4.4.3 **Өгсөн зөвлөмж:**

1. Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн, төсвийн зохистой удирдлагаар хангаж, өр төлбөрийг барагдуулж, нэмж өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах
2. Цагаан-уул сумын “Галт дулаан” ХХК-ийн дулааны шугам сүлжээ, зуухны шинэчлэлийн ажлын гэрээг яаралтай хийж, хөрөнгийг бүртгэх асуудлыг шийдвэрлэх

4.4.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна, цаашид хэрэгжүүлэн ажиллах болно

#### 4.4 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ГАРСАН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.4.1 **Илрүүлэлт:** Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулах боломжгүй нийт 4,026.0 сая төгрөгийн зөрчил үлдсэн ба түүний үнэлж үзэхэд 1,049.8 сая төгрөг нь материаллаг зөрчил байна.

4.4.2 **Эрсдэл:** Аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй, санхүүгийн үйл ажиллагаанд өмнөх алдаа зөрчил дахин давтагдах эрсдэлтэй байна.

4.4.3 **Өгсөн зөвлөмж:** Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаар илэрсэн алдаа, зөрчлийн биелэлтэд анхаарал хандуулж, хэрэгжилтийг бодитой тооцон, биелэлтийг Төрийн аудитын газарт ирүүлэх.

4.4.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна, цаашид хэрэгжүүлэн ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 25-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан</b>	<b>Аудитын код:</b>
2021 он			ХӨА/2021/01/-СТА-ТЕЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар</b>		<b>Сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын хугацаанд хэрэгжүүлсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийн төлөвлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн эргэн төлөлт, улс, орон нутаг, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн эргэн төлөлтөөс орох орлого бүрдүүлэлттэй холбоотой нийт <b>19,517.7</b> сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч байгаагаас харахад дээрх хяналтуудын үр нөлөө хангалтгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрсдэлийг оновчтой тогтоож, эрсдэлийг хаах бодлого боловсруулж, оновчтой шийдвэрт гаргахад нөлөөлж чадахгүй байна.	0	Зөвлөмж хүргүүлсэн	Засаг дарга	Ш.Идэр-баясгалан
2	Төсвийн шууд захирагч болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар төсөв захирагч нарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг нягтлан бодох бүртгэлтэй тулган хянаж үзэхэд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 1,646.4 сая төгрөгийн зөрчил, төсвийн шууд захирагч болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар 5,956.7 сая төгрөгийн зөрчил илэрч тухайн шатны төсөв захирагчид Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр журмын холбогдох заалтыг заалтыг хэрэгжүүлэн	0	Албан шаардлага	Засаг дарга	Ш.Идэр-баясгалан

	ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.				
2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа хөрөнгийн түүвэрлэх хянахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 12,078 ширхэг 6,264.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна. Энэ УСНББОУС-17 параграф 49, УСНББОУС-31 параграф 78, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т “Биет хөрөнгийн дансны бодит үнээсээ материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ” гэж заасантай нийцэхгүй байгаа ба “үнэлгээ, хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.	0	Зөвлөмж хүргүүлсэн	Засаг дарга	Ш.Идэр-баясгалан
3	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн авлагын үлдэгдэлд 2,268.8 сая төгрөгийн авлагын хугацаа хэтэрсэн ба өмнөх оноос 360.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.	360.5	Зөвлөмж хүргүүлсэн	Засаг дарга	Ш.Идэр-баясгалан
4	Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулах боломжгүй нийт 4,026.0 сая төгрөгийн зөрчил үлдсэн ба түүний үнэлж үзэхэд 1,049,8 сая төгрөг нь материаллаг зөрчил байна.	4,026.0	Зөвлөмж хүргүүлсэн	Засаг дарга	Ш.Идэр-баясгалан
5	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 2,919.8 сая төгрөгөөр буюу 48.1 хувиар, урт хугацаат өр төлбөр 7,343.0 сая төгрөгөөр буюу 189.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалттай нийцэхгүй байгаа ба “Үнэн ба зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.	0	Зөвлөмж хүргүүлсэн	Засаг дарга	Ш.Идэр-баясгалан
6	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өр төлбөр дансанд Цагаан-уул сумын “Галт дулаан” ХХК-ийн дулааны шугам сүлжээ, зуухны шинэчлэлийн	0	Зөвлөмж хүргүүлсэн	Засаг дарга	Ш.Идэр-баясгалан

	ажлын гэрээний дүнг ашиглагч, гүйцэтгэгч нарын маргаанаас болж шийдвэрлээгүй байгаа тул 2020 оны санхүүгийн тайланд тусгагдаагүй байна. Гэхдээ тус хөрөнгийг тус аж ахуйн нэгж ашиглаж, үр ашгийг нь Цагаануул сумын иргэд хүртэж байна				
	<b>Дүн</b>	<b>4,386.5.0</b>			



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
Утас: 70382300, факс: 70381001  
www.khovsgol.gov.mn

2021.04.20 № 1/895  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
О.ГАНБОЛД ТАНАА

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад хийсэн аудитын тайлангийн төсөл, зөвлөмжтэй танилцлаа. Холбогдох арга хэмжээг зохион байгуулж зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах болно.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН



My Doc/ jijig toot

971000184

## Хавсралт-2

Төвсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

Мян.төг

№	Байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Материаллаг /мянган төгрөг/	Материаллаг бус /мянган төгрөг/
1	Бүрэнтогтох сумын ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс санхүүжих санхүүжилтийг 11,951.5 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.		11,951.5
3	Ренчинлхүмбэ сумын ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 5 иргэний 57.3 сая төгрөгийн авлага байна.	57,276.8	
4	Ренчинлхүмбэ сумын ТТЗ	1. Аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 0.7 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн. 2. Орон нутгийн орлогыг нийт 6.8 сая төгрөгөөр тасалсан.		7,500.0
5	Улаан-Уул сумын ТТЗ	Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзвэл нийт 4 нэр төрлийн орлогыг 1,765.9 мянган төгрөгөөр тасалсан, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 83,000.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 42,618.5 мянган төгрөгийг төвлөрүүлж 40,381.5 мянган төгрөгийн төлөвлөгөөг тасалсан.		42,147.4
7	Улаан-Уул сумын ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 27 иргэнээс авах 75.323.0 мянган төгрөгийн авлагатай байна	75,323.0	
13	Цэцэрлэг сум ТТЗ	Мөнгөн гүйлгээний тайлангийн давхардсан орлого, зардлын устгах бичилтийг хийгээгүй		10,000.0
16	Эрдэнэбулган сум ТТЗ	Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт болох Сум хөгжүүлэх сангийн зээл болох 50,000.0 мянган төгрөгийг богино хугацаат авлагаар тайлагнасан. 2,874.0 мянган төгрөгийн давхардсан орлого болон зардлын гүйлгээний устгах бичилтийг дутуу хийсэн.		52,874.0
20	Арбулаг сум ТТЗ	Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн өмнөх онд мөнгөн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнг 31.7 мянган төгрөгийг дутуу нэгтгэсэн; Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 3,872.3 мянган төгрөгөөр авлага, 2,746.0 мянган төгрөгийн өглөг, 1,126.3 мянган төгрөгийг илүү нэгтгэсэн, Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 126.3 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлогыг илүү нэгтгэсэн.		3,998.6
22	Тариалан сум ТТЗ	Цалингийн үр дүнгийн урамшууллыг давхардуулж олгосон.	973.0	
25	Тариалан сум ТТЗ	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эцсийн үлдэгдэлд Нэгтгэгдсэн байгууллага хооронд болон төсвийн төвлөрүүлэн захирагч хооронд үүссэн 2,374.8 мянган төгрөгийн өглөг, авлага, 23,780 мянган төгрөгийн давхардсан орлого болон зардлын гүйлгээний устгах бичилтийг дутуу хийсэн.		26,154.8

26	Тосонцэнгэл ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн төсвийн гүйцэтгэл 39.3 сая төгрөгөөр тасарсан, сангийн зээлийн 52.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага, 9.4 сая төгрөгийн зээлийн хүүгийн авлага байна.	61,900	
30	Жаргал ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн эргэн төлөлтийг 67,738.7 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамжаас орох орлогыг 2,878.3 мянган төгрөгөөр, дуудлага худалдаанаас орох орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр, газрын төлбөрөөс орох орлогыг 834.3 мянган төгрөгөөр тус тус тасалсан.		72,451.3
32	Жаргал ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 125,627.5 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй ажиллаж, өмнөх оноос 42,688.4 мянган төгрөгөөр өр төлбөрийг нэмэгдүүлсэн.	42,688.4	
33	Жаргал ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг урт болон богино хугацаагаар нь ялгаж ангилаагүй бүртгэсэн.		188,134.1
35	Хатгал ТТЗ	Орлогыг нэр төрлөөр нь авч үзэхэд агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 60,0 мянган төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 94,0 мянган төгрөгөөр, газрын төлбөр 8,805,8 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 5,663,1 мянган төгрөгөөр, усны нөөц ашигласны төлбөр 11,437,1 мянган төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 18,063.4 мянган төгрөгөөр нийт 44,123.4 мянган төгрөгөөр тасалсан.		44,123.4
42	Цагаан-Үүр ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн эргэн төлөлтийг 90,343.5 мянган төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 401.7 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамжийг 1,240.0 мянган төгрөгөөр тус тус тасалсан.		91,985.2
43	Цагаан-Үүр ТТЗ	Хөрөнгийн зардалд зарцуулахаар 448,844.0 мянган төгрөгийг төлөвлөж, тайлант онд 99,893.9 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл хөрөнгийг буцаан төвлөрүүлсэн байна. Аудитаар хөрөнгө оруулалтын ажлуудыг түүвэрлэн хянахад хөрөнгийн шинж чанар агуулаагүй зүйлд зарцуулахаар хөрөнгө баталсан байна. Сумын ИТХ-ын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны 01 тоот тогтоолоор сумын ЗДТГ-ын санхүүгийн дэмжлэгийг 258,501.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тодотгосон байна. 2020 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлого /самрын/ нэмэгдэж, орон нутгийн орлого давсан боловч тухайн хөрөнгийг үр ашигтай, үндэслэлтэй, хууль, журмын дагуу төлөвлөж чадахгүй байна.		258,501.8
46		Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 84,500.0 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 72,352.9 мянган төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө 12,147.1 мянган төгрөгөөр тасарсан байна.		12,147.1
48	Ханх сумын ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 50,000.0 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 10,433.3 мянган төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө 39,566.7 мянган төгрөгөөр тасарсан.		39,566.7
50	Баянзүрх сумын ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 93,937.5 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 82,598.6 мянган төгрөгийн хүүгийн төлбөр		11,338.9

		болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө 11,338.9 мянган төгрөгөөр тасарсан байна.		
52	Шинэ-Идэр сумын ТТЗ	Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 62,000.0 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 19,733.5 мянган төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөөг 42,266.5 мянган төгрөгөөр тасалсан.		42,266.5
53	Алаг-Эрдэнэ ТТЗ	Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага нийт 103,413.2 мянган төгрөг байна. Мөн тайлант онд сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлого 11,620.3 мянган төгрөгөөр төлөвлөх байтал 5,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж 2,899.2 мянган төгрөгийг орлого төвлөрүүлсэн.		106,312.4
59	Галт ТТЗ	Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагаас хугацаа хэтэрсэн 16 иргэнтэй холбоотой 71,822.5 мянган төгрөгийн үлдэгдэл байна.	71,822.5	
60	Их-Уул ТТЗ	Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагаас хугацаа хэтэрсэн 9 иргэнтэй холбоотой 18,414.1 мянган төгрөгийн үлдэгдэл байна.	18,414.1	
61	Түнэл ТТЗ	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ЗДТГ-ын шинэ барилгын зураг төсвийн үнэ болох 25.000,0 мянган төгрөгийн насжилт өндөртэй авлагыг барагдуулах талаар арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй.	25,000.0	
62	Түнэл ТТЗ	Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагаас хугацаа хэтэрсэн 7 иргэнтэй холбоотой 57,836.2 мянган төгрөгийн үлдэгдэл байна.	57,836.2	
63	Чандмань-Өндөр ТТЗ	Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагаас хугацаа хэтэрсэн 62 иргэнтэй холбоотой 149,390.4 мянган төгрөгийн үлдэгдэл байна.	149,390.4	
64	Чандмань-Өндөр ТТЗ	ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлээр 93,265.8 мянган төгрөгийн давж биелсэн бөгөөд сумын ИТХ-ын 2020 оны 09-р сарын 30-ний өдрийн 02 дугаар тогтоолоор ЗДТГ-14.300,0 мянган төгрөг, ИТХ-1.000,0 мянган төгрөг, Соёлын төвд-2.700,0 мянган төгрөг, ОНХС-46.000,0 мянган төгрөг нийт 64.000,0 мянган төгрөгийг дээрх ТШЗ-ийн эх үүсвэрт тодотгол хийж 15.220,0 мянган төгрөгийг зарцуулж 48.780,0 мянган төгрөг зарцуулагдаагүй хэмнэлт болж орон нутгийн орлого дансанд төвлөрүүлсэн.	15,220.0	
	<b>ТТЗ-ийн Дүн</b>		<b>575,904.4</b>	<b>1,021,453.7</b>
65	Бүрэн ттогтох сумын Засаг даргын тамгын газар	Байгууллагын даргын тушаал шийдвэр гарж ажлаас чөлөөлөгдөөгүй 2 ажилтанд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн 42,262.3 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон.		42,262.3
68		COVID-19 цар тахал өвчлөл гарсантай холбоотой бэлтгэн нийлүүлэгчээс гэрээний үнийн зөрүүтэй 1,027.7 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.	1,027.7	
69	Бүрэнтогтох ЭМТ	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 15,000.0 мянган төгрөгийн өртөгтэй “Цахим эмнэлэг” программ хангамж ашиглагдахгүй байгаа нь УСНББОУС 17 “ Үндсэн хөрөнгийн “Дахин үнэлгээний загвар” хэсэгт дансны үнэ ба бодит үнэ цэний хооронд материаллаг зөрчил гарахгүй байх” үүднээс тайлагналын үеийн эцэс бүрд хөрөнгийн бодит үнэ цэнэ, ашиглалтын хугацааг тооцож үздэг байх. Шаардлагатай бол хөрөнгийг дахин үнэлэх” гэж заасанд нийцэхгүй “үнэлгээ, үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.		15,000.0

70		Байгууллагын үйл ажиллагаанд хэвийн ашиглагдаж байгаа боловч үлдэгдэл өртөггүй болсон 74 нэр төрлийн 73,574.1 төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгийг үнэлээгүй.		73,574.1
71	Бүрэнтогтох Сургууль	Бараа материалын дансанд хийсэн аудитын сорилоор “Барилгын засварын материал”-д хамаарах 4,466.6 мянган төгрөгийн тоосго 2020 оны 12 дугаар сарын 31-ээр нягтлан бодох бүртгэлээр тусгагдаж байгаа ч бодитоор оршин байхгүй.	4,466.6	
73	Бүрэнтогтох Сургууль	Тайлант оны батлагдсан төсвийн хуваарьт 4 удаагийн төсвийн зохицуулалт, 2 удаагийн тодотгол хийж 53,086.6 мянган төгрөгийн урсгал санхүүжилтийг зардал хооронд гүйлгэн зарцуулах, тодотгохдоо хэрэгцээ шаардлагыг судалсан, тооцоо судалгаа хийсэн, удирдлагын хурлаар хэлэлцсэн, тэмдэглэл хөтөлсөн гэх мэт төсвийн зохицуулалт хийх саналд тавигдах шаардлагыг хангасан баримт бүрдүүлээгүй.		53,086.6
78	Ренчинлхүмбэ ЭМТ	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй “Цахим эмнэлэг” программ хангамж ашиглагдахгүй байгаа нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө” –ийн “Дахин үнэлгээний загвар” хэсэгт “дансны үнэ ба бодит үнэ цэний хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрд хөрөнгийн бодит үнэ цэнэ, ашиглалтын хугацааг тооцож үздэг байх. Шаардлагатай бол хөрөнгийг дахин үнэлэх” гэж заасантай нийцэхгүй, “Үнэлгээ” батламж мэдэгдэл хангахгүй байна.		15,000.0
83	Ренчинлхүмбэ сургууль	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлаас 1,552.3 мянган төгрөгийг цалингийн зардлын дансанд холбогдох тушаал шийдвэргүйгээр гүйлгэн зарцуулсан.		1,552.3
84	Улаан-Уул сумын засаг даргын тамгын газар	Тус байгууллага нь ЕБС-ийн 80-н жилийн ой зохион байгуулахтай холбоотой сургуулийн гадна хашааны засварын ажилд 4.0 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардлаас зарцуулсан.		4,000.0
90	Улаан-Уул сумын СӨБ	1 удаагийн тодотгол хийж 5,694.8 мянган төгрөгийн урсгал санхүүжилтийг зардал хооронд гүйлгэн зарцуулахдаа хэрэгцээ шаардлагыг судалсан, тооцоо судалгаа хийсэн, удирдлагын хурлаар хэлэлцсэн, тэмдэглэл хөтөлсөн гэх мэт төсвийн зохицуулалт хийх саналд тавигдах шаардлагыг хангасан баримт бүрдүүлээгүй.		5,694.8
91	Мөрөн сумын Засаг даргын тамгын газар	Тус байгууллага нь тайлант онд 4,744.8 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр төлбөр үүсгэсэн.	4,744.8	
97	Авьяас	Тайлант онд 2,614.8 мянган төгрөгийн түлш, шатах тослох нормын дагуу зарцуулсан нь жолоочийн тооцооны хуудас, шатахууны орлого, зарлагын баримтаар холбогдох баримтаар баталгаажсан байна. Тайлант онд өмнөх оны үлдэгдлээс шатахууны зардал 384.0 мянган төгрөгөөр нэмэгдэж хуримтлагдсан.		384.0
100	Ирээдүй сургууль	Мобиком, Жи-мобайл ХХК тай хийсэн гэрээний дагуу ажилчдын зээлээр авсан үйлчилгээний зээлийн төлбөрийг цалингаас суутгаж 12,054.7 мянган төгрөгийг шилжүүлсэн.		12,054.7
107	Сод-Эрдэм сургууль	Тайлант онд 1,500.0 мянган төгрөгийн түлш, шатах тослох худалдан авч тайлант онд зарцуулсан байна. Зарцуулалтыг бүртгэхдээ бөөн дүнгээр бүртгэл хөтөлсөн байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах материалын үлдэгдэл 19,531.7 мянган төгрөгөөр буюу оны эхний үлдэгдлээс 26.3 дахин хэт их өсөлттэй байна.		1,500.0

110	Эрдмийн далай сургууль	Тайлант онд 970.0 мянган төгрөгийн түлш, шатах тослох нормын дагуу зарцуулсан нь жолоочийн тооцооны хуудас, шатахууны орлого, зарлагын баримтаар холбогдох баримтаар баталгаажсан байна. Тайлант онд шатахуун үлдэгдэл өмнөх оны дүнгээс 530.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн.		530.0
116	1-р цэцэрлэг	Цалингийн гүйлгээнд стандарт бус дансны харьцаа хийж гарсан зөрүүг тохируулга бичилтээр залруулга хийснээс 1060,6 мянган төгрөгөөр НДШ-ийн өглөг дутуу үүсгэсэн мэт алдаа байгаа боловч ХБИ-ээс НДШ илүү суутгасан зөрүү 573,8 мянган төгрөг, өмнө сард илүү олгосон цалинг суутган тооцохдоо гарт олгох цалингаас хасаж олгох зэргээр дансны бичилтээр тооцоо үүсгээгүйгээс дээрх алдаа гаргасан байна		1,060.6
120	3-р цэцэрлэг	Тайлант онд цалингийн зардалд тодотгол хийлгэж түлээний хөнгөлөлтөөр хүн бүрт 480,0 мянган төгрөг буюу нийт 16,440.0 мянган төгрөг олгож төсвийн тухай хуулийн 16.5.5 заалт зөрчсөн байна.		16,440.0
122	5-р цэцэрлэг	Үр дүнгийн урамшуулал илүү бодож олгосон.	1,237.1	
123		Урсгал зардлаар үндсэн хөрөнгө бэлтгэсэн		1,974.5
125	6-р цэцэрлэг	Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас тайлант онд бэлтгэсэн 9,232.2 мянган төгрөгийн хүүхдийн ор хөнжлийн даавуу, хөнжил, гудас зэрэг бараа биетээр байхгүй байна.	9,232.2	
126		Мөн 2013 онд бүртгэсэн 5280,0 мянган төгрөгийн өртөг бүхий барилгын зураг барааны үлдэгдэл бүртгэлтэй байна.		5,280.0
130	8-р цэцэрлэг	Байгууллагын байранд урсгал засвар хийж санхүүжилтийг тодотголоор шийдвэрлэхээр байсан ч шийдвэрлэгдээгүй учир Уу-жалга ХХК-д 6,000.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн		6,000.0
131	8-р цэцэрлэг	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас үндсэн цалинд 2,483.3 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан		2,483.3
139		Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих санхүүжилтийг давуулан биелүүлсэн хэдий ч туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих санхүүжилтийг 2.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.		2,582.5
141	Хөвсгөл Аймгийн Засаг даргын тамгын газар	Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас зориулалт бусаар 2,120.4 мянган төгрөгийн хүнсний материал, нутгийн брэндийг бэлтгэсэн байна. 2. Засаг даргын нөөц хөрөнгөөс Ханх суманд эрэн хайх анги байгуулах хөрөнгө оруулалтын зардалд 22,336.6 мянган төгрөг, А/44 дүгээр захирамжаар Цагаан-Уул суманд гал түймэр унтраах аврах анги байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалтын зардалд 36,588.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.		61,045.4
143	Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Он удаан жил болсон 1,829.7 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.	1,829.7	
144		Тайлант онд 8,528.8 мянган төгрөгийн түлш халаалтын өр төлбөр үүсгэсэн байна.	8,528.8	
146		ажиллаж байгаад ажлаас гарсан 1 ажилтны амралтын цалинг бодож олгоогүй өшлөг үүсгэсэн байна.	392.6	
150	Тариалан ЭМТ	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 15,000.0 мянган төгрөгийн “Цахим эмнэлэг” программ хангамж ашиглагдахгүй байгаа нь үнэлгээ батламж мэдэгдэл хангахгүй байна.		15,000.0
153	Тариалан ЕБС	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй ашиглагдахгүй байгаа ашиглалтгүй олон жил болсон 762,0 мянган төгрөгийн сургалтын программ, 150,0 мянган төгрөгийн самбарын программ байна.		912.0

154	Тариалан ЗДТГ	Үнэ төлбөргүй хүлээн авсан 22.0 мянган төгрөгийн маскийг орлогоор хүлээн зөвшөөрөөгүй.		44.0
158		Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу байгуулж үр дүнг буруу илэрхийлсэн		111.3
160	Арбулаг ЭМТ	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй “Цахим эмнэлэг” программ хангамж ашиглагдахгүй байгаа нь үнэлгээ батламж мэдэгдэл хангахгүй байна.		15,000.0
162		Арбулаг сумын эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/69 тоот тушаалыг мөрдөөгүй, байгууллагын даргын 2020 оны 4-р сарын 06-ны өдрийн А/04 тоот тушаалаар баталсан “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д зааснаар цалин хөлсийг олгосон.	3,012.9	
164	Арбулаг Хүүхдийн цэцэрлэг	Цалингийн гүйлгээнд стандарт бус дансны харьцаа хийж ХАОАТ-ын өглөгийг цалингийн зардал дансанд буруу бичилт хийсэн.		270.6
173	Эрдэнэбулган ЕБС	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 150.0 мянган төгрөгийн сургалтын программ хангамж ашиглагдахгүй байгаа нь үнэлгээ батламж мэдэгдэл хангахгүй байна.		150.0
177	Эрдэнэбулган ЭМТ	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 15,000.0 мянган төгрөгийн “Цахим эмнэлэг” программ хангамж ашиглагдахгүй байна.		15,000.0
179	Эрдэнэбулган ЭМТ	Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 10,454.4 мянган төгрөгөөр дутуу, элэгдлийн зардлыг 39,2 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, тайлант үеийн үр дүнг 10,415.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.		10,493.6
183	Цэцэрлэг сум ЕБС	2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд 2,776.7 мянган төгрөгийн дизель түлш болон бензиний үлдэгдэлтэй, Нэмэн ХХК-тай тооцоо нийлсэн актаар үлдэлгүй байгаа нь оршин байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.	2,776.7	
189	Цэцэрлэг сум ЭМТ	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 15,000.0 мянган төгрөгийн “Цахим эмнэлэг” программ хангамж ашиглагдахгүй байгаа нь үнэлгээ батламж мэдэгдэл хангахгүй байна.		15,000.0
190	Цэцэрлэг сум ЭМТ	Цалингийн зардлыг 3,217.7 мянган төгрөгөөр бууруулах бичилт хийснээр тайлант үеийн үр дүн алдаатай илэрхийлэгдсэн		3,217.7
192	Тосонцэнгэл сумын эрүүл мэндийн төв	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд: биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 15,000.0 мянган төгрөгийн үнэтэй “Цахим эмнэлэг” программ хангамж ашиглагдахгүй байна.		15,000
194	Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль	Хоолны зардал 1 хүүхдэд оногдох нормативаар тооцсон хэмжээнээс илүү 1100.9 мянган төгрөгийн зардал зарцуулсан.	1,101	
198	Тосон илч ХХК	Тайлант хугацаанд авлагатай байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулсан байна. Намуун мөрөн ХХК, Хар бухат ХХК-аас авах авлага насжилт өндөртэй байна.	6,800	
202	Нийтийн номын сан	ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албаны зөвлөмж акт албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллаагүй байна		3,952

208	Хөвсгөл захиалагчийн хяналтын төв	Улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн сан зөрүүтэй бүртгэсэн.		40,920
212	Цагаан-Үүр сумын ЕБС	Хүүхдийн үдийн цайнд зарцуулсан 6443.0 мянган төгрөгийг төрөөс иргэдэд үзүүлэх тэтгэмж урамшууллын зардалд бүртгээгүй дотуур байрны хүүхдийн хоолны зардалд бүртгэсэн, цалингийн зардлаас 9264.5 мянган төгрөгийг нийгмийн даатгалын зардалд бүртгэж зардлын бүлэг хооронд зөв ангилаагүй.		15,707.5
213		2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус байгууллагын санхүүгийн байдлын тайланд тайлагнагдсан үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 204 нэр төрлийн 140,478.7 мянган төгрөгийн анхны үнэ бүхий хөрөнгө бүртгэгдэн ашиглагдаж байгаа		140,478.7
215	Цагаан-Үүр сумын ЭМТ	Үндсэн болон биет бус хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж буй 70 нэр төрлийн 84,193.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй үндсэн болон биет бус хөрөнгө байна.		84,193.0
216		Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй 15,000.0 мянган төгрөгийн “Цахим эмнэлэг” программ хангамж ашиглагдахгүй байна.		15,000.0
